

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 22 өдөр

Дугаар 01

Хархорин сум

Компанийн 2016 оны үйл ажиллагаатай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

Компанийн 2016 оны бизнесийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 22 өдөр

Дугаар 02

Хархорин сум

2016 оны санхүүгийн тайлантай
холбогдуулан ТУЗ-ийн гаргасан
дүгнэлтийн тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

Компанийн 2016 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 22 өдөр

Дугаар 03

Хархорин сум

2016 оны ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/2017 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу 13,287.71 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан боловч компани нь ногдол ашиг хуваарилсан тохиолдолд төлбөрийн чадваргүй болохоор байгаа, түүнчлэн компани нь төлж барагдуулах шаардлагатай ихээхэн хэмжээний өр төлбөртэй байгаа тул 2016 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 22 өдөр

Дугаар 04

Хархорин сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

- ✓ Баатарын Амарсанаа;
- ✓ Сандагийн Амгалан;
- ✓ Баттулгын Бүрэн нарыг томилсугай.

Хоёр. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

- ✓ Пүрэвийн Бишрэл;
- ✓ Лхагвасүрэнгийн Хосбаяр;
- ✓ Пүрэвийн Учрал;
- ✓ Жаргалын Энхтөр;
- ✓ Цэрэндолгорын Энх-Амгалан;
- ✓ Ойдовсүрэнгийн Төмөрбаатар нарыг томилсугай.

Гурав. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилсонтой холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 04 тоот тогтоолоор томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04-р сарын 22 өдөр

Дугаар 05

Хархорин сум

Компанийн 2017 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ